



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 сны 07 сарын 04 өдөр

Дугаар 4/222

Улаанбаатар хот

Журам батлах тухай

“Агаарын тухай” хуулийн 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсгийг үндэслэн  
ТУШААХ нь:

1. “Агаарын чанарын мэдээ гаргах” журмыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Тус журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газарт, журмыг хэрэгжүүлж ажиллахыг Цаг уур, орчны шинжилгээний газарт тус тус үүрэг болгосугай.
3. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “Журам батлах тухай” 2011 оны А-131 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.ЦЭРЭНБАТ



Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын  
2018 оны 07 дугаар сарын 04-ны өдрийн  
A/222 дугаар тушаалын хавсралт

## АГААРЫН ЧАНАРЫН МЭДЭЭ ГАРГАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол улсын "Агаарын тухай" хууль, "Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай" хууль, "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай" хууль. "Гамшгаас хамгаалах тухай" хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэх, агаарын чанарын мэдээ гаргах, мэдээ мэдээллээр нийгмийн хэрэгцээг хангах ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Агаарын чанарын мэдээ нь хүрээлэн байгаа агаарын чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээний харуул, лаборатори, ажиглалтын цэгүүдэд хэмжсэн хэмжилтийн мэдээ, агаарт бохирдуулах бодис гаргадаг, эсхүл физикийн сөрөг нөлөө үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын дотоодын хяналт, бохирдлын эх үүсвэрийн мэдээ, мэдээлэл зэргээс бүрдэнэ.

1.3. Цаг уур, орчны шинжилгээний газар түүний харьяа аймаг, Нийслэлийн байгууллагууд, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар нь агаарын чанарын мэдээ, мэдээллийг бүрдүүлж төрийн захирагааны төв байгууллага, орон нутгийн удирдлага, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо болон холбогдох мэргэжлийн бусад байгууллагад мэдээллээр үйлчлэх үүргийг гүйцэтгэнэ.

1.4. Агаарын чанарын мэдээ нь анхан шатны мэдээ болон хянан баталгаажуулсан мэдээ, мэдээллээс тус тус бүрдэнэ.

Хоёр мэдээ дамжуулах

2.1. Мэдээ, мэдээллийг энгийн болон онцгой үед гэсэн үндсэн 2 горимоор дамжуулна.

2.2. Автомат багажаар хэмжигдэж буй агаарын чанарын болон агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрийн дотоодын хяналтын хэмжилтийн анхан шатны дүн мэдээ нь хариуцан ажиллуулж байгаа байгууллага, ЦУОШГ болон [www.agar.mn](http://www.agar.mn), [www.air.ub.gov.mn](http://www.air.ub.gov.mn) цахим хуудас руу шууд дамжуулагдана.

2.3. Агаарын чанарыг шууд хэмжин тодорхойлох боломжгүй бол лабораторийн шинжилгээний дүн гармагц хэмжилт хийснээс хойш 2 цагийн дотор ЦУОШГ-т дамжуулна.

2.4. Техникийн шалтгаанаар хугацаандаа дамжиж чадаагүй мэдээг гарсан гэмтэл saat алар даруйд нөхөн дамжуулна.

2.5. Хүрээлэн байгаа агаар дахь бохирдуулах бодисын агууламж тасралтгүйгээр 24 цагийн туршид агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас хэд дахин хэтэрсэн бохирдол илэрсэн болон илрэх магадлалтай тохиолдолд анхаарах, сэрэмжлүүлэх мэдээг онцгой горимоор шуурхай дамжуулна.

2.6. Агаарын бохирдлын суурин эх үүсвэрээс гаргах бохирдуулах бодисын агууламж стандарт дахь зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн, гэнэтийн аюул, үйлдвэрийн ослын болон аваарын горимоор ажилласан тохиолдолд тухайн суурин эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага онцгой горимоор мэдээг шуурхай дамжуулж

ажиллана.

2.7. Агаарын бохирдлын томоохон эх үүсвэрүүд дотоодын хяналтыг шууд хэмжин тодорхойлох боломжгүй бол сард 2-оос доошгүй удаа хэмжилт хийж, хэмжилтийн дүн мэдээг энэхүү журмын Хүснэгт 2-ийн дагуу гаргаж дамжуулна.

2.8. Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн мэдээг аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвүүд, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар тус тус гаргаж ЦУОШГ-т дамжуулна.

2.9. [www.agaar.mn](http://www.agaar.mn) цахим хуудаст шууд дамжуулагдсан агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэл, дотоодын хяналтын дүн мэдээтэй төрийн захиргааны төв байгууллага, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо, Мэргэжлийн хяналтын байгууллага, ЦУОШГ, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар зэрэг мэргэжлийн байгууллагууд танилцах, хяналт тавих эрхтэй байна.

Гурав. Агаарын чанарын мэдээгээр нийгмийн хэрэгцээг хангах

3.1. Агаарын чанарын мэдээгээр мэдээлэх үйл ажиллагаанд шуурхай, ойлгомжтой, хариуцлагатай байх зарчмыг баримтална.

3.2. Агаарын чанарын мэдээ гаргахдаа хэвлэмэл, цахим, онлайн хэлбэрээр үйлчилнэ.

3.3. Хугацаатай тогтмол гаргадаг мэдээг тогтоосон хугацаанд нь, тухайн цаг үеийн мэдээг шуурхай байдлаар гаргана.

3.4. ЦУОШГ, түүний харьяа байгууллагууд болон Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар Хүснэгт 1-д заасан мэдээ, мэдээллийг заасан хугацаанд энгийн горимоор гаргаж мэдээнэ.

3.5. Агаар бохирдуулах бодисын агууламж стандартад заасан хүлцэх агууламжаас давсан, хүн амын эрүүл мэндэд ноцтой нөлөөлөх хэмжээнд хүрсэн буюу хүрэх нөхцөл бүрдвэл аймаг, нийслэлийн агаарын чанарын хяналт шинжилгээний холбогдох байгууллага (аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төв, Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газар) нь орон нутгийн удирдлага, олон нийтэд онцгой горимоор шуурхай мэдээлэх ажлыг хариуцна.

3.6. Агаарын чанарын тайлан, мэдээг ЦУОШГ, түүний орон нутаг дахь салбар нь долоо хоног, сар, улирал, жилээр эмхэтгэн төр, засгийн болон төрийн захиргааны төв байгууллага, орон нутгийн байгууллагыг мэдээ, мэдээллээр хангана.

3.7. Хүрээлэн байгаа агаарын чанарын талаарх онлайн мэдээллийг [www.agaar.mn](http://www.agaar.mn), [www.air.us.gov.mn](http://www.air.us.gov.mn) цахим хуудаснуудаар мэдээлэх бөгөөд бусад мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээллийг өгч болно.

Дөрөв. Мэдээллийн сан

4.1. Агаарын чанарын хяналт шинжилгээний улсын сүлжээний цэгүүдэд хэмжигдсэн хэмжилтийн дүн мэдээ, агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн мэдээ, томоохон суурин эх үүсвэрийн дотоодын хяналтын цэгийн мэдээгээр мэдээллийн сан үүссэн байна.

4.2. Улаанбаатар хотын агаарын чанарын өдөр тутмын мэдээг сар бүр, аймаг, нийслэлийн агаарын чанарыг хянах харуулын жилийн дундаж мэдээг дараа оны 1 дүгээр улиралд гаргаж, байгаль орчны мэдээллийн сан [www.eic.mn](http://www.eic.mn) цахим хуудасны агаарын чанарын мэдээллийн санг бүрдүүлнэ.

Тав хариуцлага

5.1. Агаарын чанарын мэдээ, мэдээллийг бүрдүүлэх, нэгтгэх, мэдээлэх, үйлчлэх ажлыг ЦУОШГ, түүний харьяа байгууллагууд, Нийслэлийн агаарын бохирдлыг

бууруулах газар болон агаарын бохирдлын томоохон эх үүсвэрүүд хариуцна.

5.2. Мэдээ дамжуулах, бүрдүүлэх, мэдээлэх байгууллага нь олон нийтэд түгээх мэдээг хугацаа хоцроосон эхний тохиолдолд, онцгой горимын мэдээгээр хангаагүй үүрэг бүхий албан тушаалтан, байгууллагад анхааруулах арга хэмжээ авна.

5.3. Зөрчлийг удаа дараалан давтан гаргасан, текстийн алдаатай мэдээлэл гаргасан, уг мэдээ, мэдээллээр хугацаанд нь үйлчлэгүйн улмаас хүний эрүүл мэнд болоод байгаль орчинд хохирол учирсан тохиолдолд Төрийн албаны тухай хуулийн дагуу хариуцлага тооцно.

Хүснэгт 1. Агаарын чанарын мэдээ, мэдээллээр энгийн горимд үйлчлэх мэдээ

№	Мэдээ, мэдээллийн агуулга	Хугацаа	Хариуцагч
Агаарын чанарын хяналт, шинжилгээний мэдээ			
1	Улаанбаатар хотын агаарын чанарын өдөр тутмын мэдээ	Өдөр бүр /автоматаар/	ЦУОШГ НАББГ БОХЗТЛ
2	Улаанбаатар хотын агаарын чанарын 7 хоногийн тойм мэдээ	Даваа гараг бүр	ЦУОШГ НАББГ БОХЗТЛ
3	Улаанбаатар хотын агаарын чанарын хүйтний улирлын мэдээ	11-12, 1-5-р саруудад	ЦУОШГ
4	Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын агаарын чанарын сарын статистик мэдээ	Сар бурийн 3-ны дотор	ЦУОШГ
5	Улаанбаатар хотын агаарын чанарын жилийн тойм мэдээ	Дараа жилийн 1-р улиралд	ЦУОШГ
6	Орон нутгийн агаарын чанарын мэдээ	Улирал бүр	Аймгийн ЦУОШГ
7	Орон нутгийн агаарын чанарын жилийн тойм мэдээ	Дараа жилийн 1-р улиралд	ЦУОШГ
Агаарын бохирдлын эх үүсвэрийн мэдээ			
1	Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн нэгдсэн мэдээ	Дараа жилийн 2-р улиралд	ЦУОШГ, НАББГ Аймгийн УЦУОШТ
2	Агаарын бохирдлын эх үүсвэрийн тоо бүртгэлийн нарийвчилсан мэдээ	Дараа жилийн 2-р улиралд	ЦУОШГ, НАББГ, Аймгийн УЦУОШТ
3	Агаарын бохирдлын томоохон эх үүсвэрийн дотоодын хяналтын мэдээ	Улирал бүр	Аж ахуйн нэгж, байгууллага

Хүснэгт 2. Агаарын чанарын мэдээ, мэдээллээр онцгой горимд үйлчлэх мэдээ

	Мэдээ, мэдээллийн агуулга	Хугацаа	Хариуцагч
Агаарын чанарын хяналт шинжилгээний мэдээ			
1	Хүрээлэн байгаа агаарын чанар тасралтгүйгээр 24 цагийн туршид агаарын чанарын стандарт дахь хүлцэх агууламжаас хэтэрсэн бохирдол илэрсэн болон илрэх магадлалтай тохиолдолд	Тухайн үед	НАББГ, Аймгийн УЦУОШТ

2	Aгаарын бохирдлын суурин эх үүсвэрээс гаргах бохирдуулах бодисын агууламж стандарт дахь, гэнэтийн аюул, үйлдвэрийн ослын болон аваарын горимоор ажилласан тохиолдолд	Тухайн үед	Аж ахуйн нэгж, байгууллага, НАББГ, Аймгийн УЦУОШТ
---	--	------------	---

Хүснэгт 3 Агаарын бохирдлын суурин эх үүсвэрийн дотоодын хяналтын мэдээ

Эх үүсвэрийн нэр, байршил	Хэмжилтийн цэг, зуухны хүчин чадал	Хэмжилт хийсэн он, сар, өдөр, цаг	Бохирдуулах бодисын ялгарлын хэмжээ, нмг/м <sup>3</sup>				Хаягдал утаа цэвэрлэх, шүүх төхөөрөмж, A.Y.K	Хаягдал утааны хийн хурд, температур	Хэмжилтийн араа аргачлал, багажийн нэр
			SO <sub>x</sub>	NO <sub>x</sub>	CO	TSP			

Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газар